



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Japan International  
Cooperation Agency



ADB ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

ЭРҮҮЛ МЭНД

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

---

Суралцагчийн үнэлгээ .....	2
----------------------------	---

## **БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

---

Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж .....	5
Хоёр. Нэгж үнэлгээний жишиг даалгавар .....	9
2.1. Сонгох даалгаврын жишээ, аргачлал .....	9
2.2. Задгай даалгаврын жишээ, аргачлал .....	13
Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал .....	22

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-т суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup>Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.





## Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

Эрүүл мэнд хичээлийн хувьд суралцахуйн удирдамжид тусгасан үндсэн 6 чиглэл буюу бүлэг сэдвийг нэгж болгон авсан. Тиймээс үнэлгээний нэгж нь бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин дэх бүх ангид ижил байна. Энэ нь боловсролын түвшин тус бүрт сурагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг тэдгээр нэгж бүрээр үнэлж, үр дүнг тооцох давуу талыг бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл, үнэлгээний нэгжийг ашиглан хөндлөн болон босоо байдлаар үнэлгээг хийх бүрэн боломжтой юм. Эдгээр 6 нэгж тус бүрээр сурагчийн ахиц дэвшлийг анги тус бүрт төдийгүй боловсролын түвшин тус бүрт сурагчид өөрсдөө болон хөндлөнгөөс үнэлж, үр дүнг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийж болно.

Суралцахуйн үр дүн нь бидний хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал юм. Тиймээс суралцахуйн үр дүнг боловсруулахдаа зөрүүг нөхөх зарчмыг баримталсан болно. Тус зарчимд тулгуурлан дараах алхмын дагуу тунгаан бодож суралцахуйн үр дүнг томьёолсон. Үүнд:

- Одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлох
- Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлын хооронд ямар зөрүү байгааг олж илрүүлэх
- Мэдлэг, чадвар, хандлагатай холбоотой ямар цоорхой байгааг тодорхойлох
- Тус зөрүү буюу дутуу зүйлийг хэрхэн нөхөхийг тодорхойлох

Нэгж тус бүрийн хүрээнд одоогийн нөхцөл байдлыг бодит мэдээ баримт, тулгамдсан асуудалд үндэслэн тодорхойлсон. Тухайлбал, нөхөн үржихүйн эрүүл мэнд нэгжийн хүрээнд хүүхэд өсвөр үеийнхэнд нас, сэтгэл зүйн онцлогтой холбоотой ямар асуудлууд нийтлэг тулгамддаг талаарх бодит мэдээ баримтыг ашиглан одоогийн нөхцөл байдлыг төсөөлөн тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, тухайн нэг ангийн түвшинд буюу тодорхой нэг насанд сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой ямар асуудал тулгардаг болохыг тодорхойлно.

Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал нь одоогийн нөхцөл

байдал шийдвэрлэгдсэн байх тэр цаг мөч бөгөөд энэ нь ямар байдлаар шийдвэрлэгдсэн байхыг томъёолсон томъёоллыг хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал гэж үзэж болно.

Одоогийн болон хүрэхийг хүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлсны дараа эдгээрийн хооронд ямар зөрүү байгааг илрүүлнэ. Үүний тулд одоогийн нөхцөл байдлаас хүсэж буй нөхцөл байдалд хүрэхэд юу дутаад байгааг олж тогтооно. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр нөхцөл байдлын зөрүүг үүсгэж буй шалтгааныг тодорхойлно.

Ийнхүү тус шалтгаан бүхий зөрүүг олж илрүүлэн, түүнийг хэрхэн нөхөхийг томъёолсон томъёолол нь суралцахуйн үр дүн болно. Энэ нь сурагчдын эрүүл мэндийн боловсролын хэрэгцээтэй нягт уялдаатай юм.

Зөрүү нөхөгдөж, өөрчлөлт гарсан эсэхийг буюу хүссэн үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойж буй байдал нь үнэлгээ юм. Тус өөрчлөлтийг хэрхэн хэмжихийг илэрхийлж буй зүйл нь үнэлгээний арга юм.

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нэгжийн хүрээнд суралцахуйн үр дүнг боловсруулахдаа дээрх зөрүүг нөхөх зарчмыг баримтлахын зэрэгцээ бэлгийн боловсролын чиглэлээр хүүхэд өсвөр үеийнхний нас, сэтгэл зүйн онцлогтой уялдуулан зөвлөмжилсөн олон улсын зөвлөмжид тулгуурласан болно.

Дээрх зүйлийг жишээний хамтаар дараах хүснэгтээр харуулж байна.

**Хүснэгт 1.**

Одоогийн нөхцөл байдал	Хүрэхийг хүсэж буй нөхцөл байдал	Илэрсэн зөрүү	Мэдлэг, чадвар, хандлагын улмаас үүссэн зөрүү	Суралцахуйн үр дүн
Одоо юу болж байна вэ? /одоо ямар байна вэ?	Юу болох ёстой вэ? / ямар байх ёстой вэ?	Ямар байгаа болон ямар байх ёстой хоёрын зөрүү, ялгаа нь юу вэ?	Та одоогийн нөхцөл байдлыг ямар учраас байгаа гэж боддог вэ?	Хичээлийн үйл ажиллагаанд оролцсоны үр дүнд сурагчид юу чаддаг болсон байхыг та хүсэж байна вэ?
Өсвөр насныхан бусадтай үр дүнтэй харилцаж чадахгүй байна	Өсвөр насныхан бусадтай үр дүнтэй харилцаж чаддаг байх	Тэд хэрхэн харилцвал үр дүнтэй харилцаа болохыг мэддэггүй	М: харилцаанд юуг анхаарах хэрэгтэйг мэдэхгүй Ч: бусадтай зөвшилцөж, үр дүнтэй харилцаж чадахгүй Х: өөрийн болон бусдын эрх үүрэг, хил хязгаар, хүсэлт хэрэгцээг бодолцдоггүй	Эрх, үүрэг, хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан бусадтай зөвшилцөн, үр дүнтэй харилцаж чаддаг болно.

Үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

- ✓ Нэгж хичээлийг судалснаар сурагчдад бодитой ямар өөрчлөлт гарахыг тооцоолох
- ✓ Багш тухайн өөрчлөлтийг хэрхэн үнэлэхээ тодорхойлох
- ✓ Бодит чадварын үнэлгээг орхигдуулахгүй байхад анхаарах
- ✓ Агуулга, үйл явц, чанар, үр нөлөөг үнэлэхэд чиглэгдсэн байх

Гүйцэтгэлийн 4 түвшинг боловсруулахдаа дараах зарчимд тулгуурласан. Үүнд:

- ✓ Гүйцэтгэлийн түвшин тус бүр нь сурагчдын бодит байдлыг үнэлэх боломжтой байх ба оноожуулах боломжтой байх
- ✓ Цогц байх буюу гүйцэтгэлийн чанарын талаар дүгнэлт хийх боломжтой байх
- ✓ Үнэлгээний шалгуурт суурилсан байх буюу түүний цар хүрээнээс хэтрэхгүй байх

Бид бүрэн дунд боловсролын түвшинд 10 дугаар ангийн “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” нэгжийг сонгон авч, тус нэгжийн хүрээнд үнэлгээг хэрхэн хийх талаар энэхүү зөвлөмждөө тусгасан. Үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа дараах үзэл баримтлалыг мөрдлөг болгосон.

Үнэлгээний гол зорилго бол сурагчдын ахиц дэвшил, хөгжлийг дэмжихэд оршино. Үнэлгээ нь сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг зөвхөн үнэлэх төдий зүйл бус харин суралцагчид хэрхэн суралцаж байгааг илрүүлэх, суралцах үйл ажиллагааг хэрхэн өрнүүлэхийг шийдвэрлэх, сурагч цаашид хэрхэн суралцах стратегийг сонгох, түүнчлэн сургалтын агуулга ба сургалтын заах арга зүйг сайжруулах, сургалтад ашиглах хэрэглэгдэхүүнийг баяжуулахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, сурагчийн сурах үйл явц болон багшийн сургах үйл явцыг сайжруулахад ашиглагдана. Тиймээс багш нар үнэлгээ хийхдээ дээрх зорилгыг санаж байх нь чухал юм.

Боловсролын салбарын практик үйл ажиллагааны хүрээнд гарааны, явцын болон үр дүнгийн үнэлгээг хэрэглэдэг. Гарааны үнэлгээ нь тухайн хичээлийг зааж эхлэхийн өмнө сурагчийн мэдлэг, чадвар, хандлага ямар байгааг илрүүлэх ба тус үнэлгээний үр дүнг явцын болон эцсийн үнэлгээтэй харьцуулан сурагчийн ахиц, хөгжлийг тодорхойлоход ашиглана.

Явцын үнэлгээ нь сурагч хичээлийн явцад хэрхэн суралцаж байгааг илрүүлэх ба энэ нь багш, сурагчийн хувьд дараах шийдвэр гаргахад хэрэглэгдэнэ. Үүнд:

- ✓ Сурагчийн хувьд цаашид хэрхэн суралцах арга замаа тодорхойлох
- ✓ Багш нарын хувьд сурагчдын суралцах үйл явцыг хэрхэн өрнүүлэх, сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг хэрхэн сайжруулах талаар шийдвэр гаргах

Үр дүнгийн үнэлгээг тухайн хичээлийн жилийн эцэст хийх бөгөөд энэ нь дараах зорилгыг хангахад чиглэгдэнэ. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн хичээлийг судалж дууссаны дараа сурагч тус бүр юу мэддэг, чаддаг болж, ямар итгэл үнэмшил, хандлагатай болсныг тодорхойлохын зэрэгцээ сурагчдад тухайн хичээлийг ямар түвшинд судалсныг харуулах дүн тавина.
- ✓ Тухайн сургалтын хөтөлбөрийн зорилго хэр зэрэг биелэгдсэн, үр дүндээ хэр хэмжээгээр хүрснийг дүгнэнэ. Тус үнэлгээ дүгнэлтийг сурагчийн өвөрмөц ялгаатай бүлгээр, нэг сургуулийн эрүүл мэндийн хичээл зааж буй багш тус бүрээр, мөн сургууль, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээнд гэх зэргээр хийж судлан шинжлэх ба улмаар бодлогын шийдвэр гаргахад ч ашиглах боломжтой.

Бид энэхүү зөвлөмждөө эрүүл мэнд хичээлийн үр дүнг хэрхэн үнэлэх, тус үнэлгээнд үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүнийг хэрхэн ашиглах талаар тусгасан болно. Үүнийг өөрсдийн үйл ажиллагаандаа тусган авч, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тус зөвлөмжид тусгагдсан нэр томъёо болон үндсэн ухагдахууныг ямар утга агуулгаар хэрэглэсэн болохыг мэдэх хэрэгтэй. Энэ хэсэгт бид дараах нэр томъёонуудыг тайлбарлах болно.

### Тус зөвлөмжид хэрэглэгдэж буй нэр томъёоны тайлбар

**Шалгуур:** Энэ нь сурагчийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглах удирдамж бөгөөд ихэвчлэн харьцангуй жижиг агуулгын нэгжийг хамрах ба заавартай нягт холбоотой байдаг. Мөн сурагчийн хийсэн зүйлийг гүйцэтгэлийн хэмжүүрийн дагуу үнэлэх үнэлгээний рубрикийг боловсруулахад үндэс суурь болно.

**Бодит чадварын үнэлгээ:** Үндсэн мэдлэг, чадвараа зөв хэрэглэж ашиглаж байгаа эсэхийг харуулахуйц бодит амьдрал дээрх үйлдлийг хийж гүйцэтгүүлэх үнэлгээний хэлбэр. Бодит чадварын үнэлгээний шалгуур нь мэдлэг бүтээх, эрэл хайгуул хийх, хичээл сургалтын үйл ажиллагаанаас бусад нөхцөлд эзэмшсэн мэдлэг, чадвараа амжилттай ашиглаж хэрэглэх зэргийг багтаана.

**Гүйцэтгэлийн стандарт:** Тодорхой агуулга ба/эсвэл чадварын түвшинд өөрийн мэддэг чаддаг зүйлээ харуулахын тулд хүүхдийн хийх ёстой зүйлийг илэрхийлсэн тодорхойлолт

### Нотолгоо буюу үнэлгээний шалгуурын дагуу үнэлгээ хийсэн баримт мэдээлэл

10 дугаар ангийн “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” нэгжийн хүрээнд үнэлгээний шалгуур тус бүрээр дараах зүйлсийг бүрдүүлж, баримт нотолгоо болгон ашиглах боломжтой. Эдгээрээс бид заримыг нь ашигласан болно.

<p><b>Үнэлгээний шалгуур 1:</b> Харилцааны эрх, үүргийн дагуу өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан харилцан зөвшилцөх замаар хэрхэн үр дүнтэй харилцахыг харуулдаг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Мэдлэг, чадварыг үнэлэх асуултын хуудас, түүнийг үнэлсэн рубрик</li> <li>• Эхлэх/ зогсоох/ үргэлжлүүлэх картын хуудас</li> <li>• Ярилцлагын хуудас болон ярилцлагын тэмдэглэл, үнэлгээ өгсөн баримт</li> <li>• Оюуны зураглалын /mind map/ хуудас, түүнд үнэлгээ өгсөн баримт</li> </ul>
<p><b>Үнэлгээний шалгуур 2:</b> Жирэмслэхээс сэргийлэх нийтлэг аргуудын давуу, сул талд тулгуурлан, тэдгээрийг хэрхэн зөв хэрэглэхийг оновчтой тайлбарладаг</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Дасгал ажлын хуудас, үнэлгээ өгсөн баримт</li> <li>• Бүтээлийн сан, түүнийг рубрикээр үнэлсэн хуудас</li> <li>• Агуулгын зураглалын /concept map/ хуудас, үнэлгээ өгсөн баримт</li> <li>• Бөглөсөн сорил ба сорилд үнэлгээ өгсөн баримтын хуудас</li> <li>• Өөрийн үнэлгээний бөглөсөн хуудас ба түүнд оноо өгсөн багшийн бүртгэл</li> </ul>
<p><b>Үнэлгээний шалгуур 3:</b> Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхой шалгуурын дагуу эргэцүүлэн, дүн шинжилгээ хийдэг.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурталчилгааны материал ба түүнд үнэлгээ өгсөн хуудас</li> <li>• Эсээ ба түүнийг шалгуурын дагуу үнэлсэн баримт</li> <li>• Хандлагын үнэлгээний хуудас, түүнд оноо өгсөн багшийн бүртгэл</li> </ul>

## Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

### 2.1. СОНГОХ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

#### Үнэлгээний даалгавар 1: Сорил бөглөх

Үнэлгээний даалгаврын зорилго:	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл, түүний давуу, сул тал, зөв хэрэглэх талаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Гарааны болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Сонгох
Нотлох баримт:	Сурагчийн бөглөсөн тестийн хуудас, үнэлгээ өгсөн хуудас
Гүйцэтгэх хугацаа:	30 – 40 минут

Дараах сорилыг сурагчдад тараан өгч бөглүүлнэ.

#### Сорилын хуудас

Сурагчийн нэр: \_\_\_\_\_

Он сар өдөр: \_\_\_\_\_

#### Заавар:

А. Дараах асуулт тус бүрийг анхааралтай уншаад, өөрийн сонгосон хариултын өмнөх үсэг эсвэл тоог дугуйлна уу.

1. Дараах аргуудаас аль нь жирэмслэхээс сэргийлэх байнгын арга хэрэгсэлд хамаарах вэ? (2 оноо)

А. Бэлгэвч

Г. Умайн гуурсан хоолойг боох

Б. Дааврын эм

Д. Суулгац

В. Ерөндөг

Е. Үрийн сувгийг боох

1. А, Б, Г

2. Б, В, Г

3. Г, Е

4. Г, Д, Е

2. Жирэмслэхээс сэргийлэх хаалтын арга хэрэгсэлд ямар зүйлс багтдаг вэ? (3 оноо)

А. Бэлгэвч

Г. Умайн хүзүүний таглаа

Б. Спермицид

Д. Дааврын эм

В. Ерөндөг

Е. Үтрээний хаалт

1. А, В, Г, Е

2. А, Б, Г, Е

3. Б, В, Г, Е

4. А, Г, Д, Е

3. Өсвөр насныханд хамгийн тохиромжтой нэг аргыг сонгоно уу. (2 оноо)

А. Бэлгэвч

Г. Тэвчих

Ж. Умайн гуурсан хоолойг боох

Б. Гадуур тавих

Д. Суулгац

З. Үрийн сувгийг боох

В. Ерөндөг

Е. Тариа

К. Үтрээний хаалт

4. Жирэмслэхээс сэргийлэх ямар арга хэрэгсэл урт удаан хугацаанд өндөр үр дүнтэй боловч мэс ажилбар шаарддаг сул талтай байдаг вэ? (2 оноо)  
 А. Бэлгэвч Г. Дааврын эм Ж. Умайн гуурсан хоолойг боох  
 Б. Гадуур тавих Д. Суулгац З. Үрийн сувгийг боох  
 В. Ерөндөг Е. Тариа К. Үтрээний хаалт
5. Жирэмслэхээс сэргийлэх ямар арга хэрэгсэл маш өндөр үр дүнтэй, олдоц сайтай давуу талтай боловч зарим гаж нөлөөтэй, өдөр бүр хэрэглэх шаардлагатай гэх зэрэг сул талтай байдаг вэ? (2 оноо)  
 А. Бэлгэвч Г. Дааврын эм Ж. Умайн гуурсан хоолойг боох  
 Б. Гадуур тавих Д. Суулгац З. Үрийн сувгийг боох  
 В. Ерөндөг Е. Тариа К. Үтрээний хаалт
6. Жирэмслэхээс сэргийлэх ямар арга хэрэгсэл өндөр үр дүнтэй, БЗДХ-аас хамгаалах давуу талтай боловч хэрэглэхэд таагүй мэдрэмж төрүүлдэг сул талтай байдаг вэ? (2 оноо)  
 А. Бэлгэвч Г. Дааврын эм Ж. Умайн гуурсан хоолойг боох  
 Б. Гадуур тавих Д. Суулгац З. Үрийн сувгийг боох  
 В. Ерөндөг Е. Тариа К. Үтрээний хаалт
7. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн давуу, сул талаас шалтгаалан хүн бүр өөрт тохирох аргыг сонгож хэрэглэнэ. (1 оноо)  
 А. Тийм Б. Үгүй
8. Жирэмслэхээс сэргийлэх аргуудын үр дүн нь зааврын дагуу хэрэглэсэн эсэхээс хамаарахгүй. (1 оноо)  
 А. Тийм Б. Үгүй
9. Ердийн хэрэглэгчдийн хувьд ч жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл нь өндөр үр дүнтэй байдаг. (1 оноо)  
 А. Тийм Б. Үгүй
10. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхдээ мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч, өөрт тохирох хэрэгслийг ном журмын дагуу хэрэглэх шаардлагатай. (1 оноо)  
 А. Тийм Б. Үгүй

Б. Дараах хүснэгт дэх өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад, өөрийн санал бодлыг илэрхийлэх хариултыг сонгож, түүнд харгалзах тоог дугуйлна уу. Үүнд:

Бүрэн санал нийлнэ – 5, Санал нийлнэ – 4, Эргэлзэж байна – 3, Санал нийлэхгүй – 2, Огт санал нийлэхгүй – 1

№	Өгөгдөл	Хариулт				
		5	4	3	2	1
1.	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн талаар заавал мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах шаардлагагүй	5	4	3	2	1
2.	Миний хувьд жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн талаар одоохондоо сайн судлах хэрэгтэй гэж бодохгүй байна.	5	4	3	2	1
3.	Хосууд хэрвээ хүүхэдтэй болохыг төлөвлөөгүй бол өөрсдөдөө тохирох жирэмслэхээс сэргийлэх ямар нэг аргыг заавал сонгож хэрэглэдэг байх ёстой	5	4	3	2	1
4.	Бэлгэвч хэрхэн хэрэглэхийг өсвөр насныханд заах нь буруу зүйл биш.	5	4	3	2	1
5.	Бэлгэвч нь хүсээгүй жирэмслэлтээс гадна бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлдэг учраас хүн бүр зөв хэрэглэж хэвших хэрэгтэй гэж би боддог	5	4	3	2	1

**Сорилын А хэсгийн зөв хариулт:** 1-3, 2-2, 3-Г, 4-Ж; 3, 5-Г, 6-А, 7-А, 8-Б, 9-Б, 10-А

**Сорилын Б хэсгийн зөв хариулт:**

Сорилын Б хэсэг нь жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлтэй холбоотой хандлагыг үнэлэхэд чиглэгдсэн болно. Хандлагын асуултыг шууд зөв буруу гэж үнэлэх боломжгүй ч тус сэдвийг судалснаар сурагчдад төлөвшүүлэхийг хүсэж буй хандлага ямар түвшинд байгааг үнэлж дүгнэлт хийнэ. Тус хандлагын асуултын хүрээнд сурагчид дараах оноо авах сонголтыг хийсэн бол бидний зорилго биелэгдсэн буюу хичээлийн үр дүн гарсан гэж үзнэ.

- Өгөгдөл 1: 1-ийг сонговол 2 оноо; 2-ыг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 2: 1-ийг сонговол 2 оноо; 2-ыг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 3: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 4: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй
- Өгөгдөл 5: 5-ыг сонговол 2 оноо; 4-ийг сонговол 1 оноо; бусад сонголт оноогүй

Дээрх үнэлгээний сонгох даалгаврыг гүйцэтгэснээр нийт 10 оноо авах ёстой ба сурагчийн авсан оноог дараах байдлаар түвшинчлэн үнэлгээ өгч болно.

- Хангалтгүй: 0-1 оноо
- Дунд зэрэг: 2-4 оноо
- Хангалттай: 5-7 оноо
- Хангалттай сайн: 8-10 оноо

**Үнэлгээний даалгавар 2. Өөрийн үнэлгээ хийх**

Үнэлгээний даалгаврын зорилго:	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нэгжийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг өөрийн үнэлгээ хийж тодорхойлох
Үнэлгээний төрөл:	Гарааны болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Сонгох
Нотлох баримт:	Өөрийн үнэлгээний бөглөсөн хуудас
Гүйцэтгэх хугацаа:	15 – 20 минут

Өөрийн үнэлгээний дараах хуудсыг сурагчдад өгч бөглүүлнэ. Тухайн өөрийн үнэлгээг хийхдээ бодитой үнэлэхийг сурагчдад анхааруулна.

**Өөрийн үнэлгээний хуудас**

Сургууль: \_\_\_\_\_ Анги: \_\_\_\_\_

Хичээлийн нэр: \_\_\_\_\_

Судалсан сэдвийн нэр: \_\_\_\_\_

Сурагчийн нэр: \_\_\_\_\_ Он сар өдөр: \_\_\_\_\_

**Заавар:** Дараах өгөгдөл тус бүрийг анхааралтай уншаад, үндсэн 3 чиглэлийн дагуу өөрт тохирох хариултыг сонгож,  тэмдэглэгээ хийнэ.

Шалгуур	Тухайн зүйлийн талаар хэр зэрэг түвшинд ойлголт мэдлэгтэй болсон гэж үзэж байна вэ?	Үүнийг бодит нөхцөлд хэрэглэх чадварыг ямар түвшинд эзэмшсэн гэж үзэж байна вэ?	Таны хувьд тухайн зүйлийн талаар нэмж судлах шаардлагатай гэж үзэж байна уу?
1. Харилцаан дахь хувь хүний эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

2. Өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарын хүндэтгэх	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
3. Харилцан зөвшилцөн, үр дүнтэй харилцах	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
4. Жирэмслэхээс сэргийлэх аргуудын давуу, сул талыг тайлбарлах	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
5. Жирэмслэхээс сэргийлэх аргуудыг хэрхэн зөв хэрэглэхийг тайлбарлах	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
6. Жирэмслэхээс сэргийлэх аргуудыг зөв хэрэглээгүй тохиолдолд яагаад үр дүнгүй болохыг тайлбарлах	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
7. Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдлыг тодорхойлох	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
8. Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн эх сурвалжийг тодорхой шалгуурын дагуу эргэцүүлэн дүн шинжилгээ хийх	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
9. Бэлгийн амьдралын талаар өөрийн ашиглах мэдээллийн эх сурвалжийг зөв сонгох	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Маш сайн <input type="checkbox"/> Дунд зэрэг <input type="checkbox"/> Тааруухан	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй

**Оноожуулах аргачлал:**

Өөрийн үнэлгээний хуудаст байгаа түвшинчилсэн утгыг дараах байдлаар оноожуулна.

- Маш сайн – 3 оноо
- Дунд зэрэг – 2 оноо
- Тааруухан – 1 оноо

Харин нэмж судлах хэрэгтэй эсэхийг илэрхийлсэн хариултад оноо өгөх шаардлагагүй. Тиймээс өгөгдөл тус бүрээр 2 асуултын хариултын оноог нэмж нийлбэр оноог гаргана. Сурагчийн нийт авах оноо 18 – 54 оноо байна. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн ашиглаж болно.

- Хангалтгүй: 18-29 оноо
- Дунд зэрэг: 30-39 оноо
- Хангалттай: 40-49 оноо
- Хангалттай сайн: 50-54 оноо



## 2.2. ЗАДГАЙ ДААЛГАВРЫН ЖИШЭЭ, АРГАЧЛАЛ

### Үнэлгээний даалгавар 1. Эсээ бичих

Үнэлгээний даалгаврын зорилго:	Дотно харилцаан дахь хувь хүний эрх, үүрэг хариуцлагын талаарх мэдлэг; бусадтай харилцахдаа өөрийн болон бусдын хүсэлт, хэрэгцээ, хил хязгаарыг харгалзах нь яагаад чухал болохыг ухаарсан эсэх хандлагыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Өгсөн чиглэлийн дагуу бичсэн эсээ, түүнд үнэлгээ өгсөн хуудас
Гүйцэтгэх хугацаа:	1 долоо хоног

Дотно харилцаан дахь эрх, үүрэг хариуцлага сэдвийн хүрээнд эсээ бичих удирдамж

**Заавар:** Өгсөн асуултын дагуу тунгаан бодож, өөрийн санаа бодлыг 500-600 үгэнд багтаан бичнэ. Эсээ нь эхлэл, үндсэн хэсэг, төгсгөл хэсэг гэсэн бүтэцтэй байх ба дүгнэлт саналаа тодорхой илэрхийлсэн байна.

Чиглүүлэх асуулт:

- ✓ Дотны хүнтэйгээ болон бусадтай харилцахдаа бид хувь хүний ямар эрх, үүрэг хариуцлагыг ухамсарласан байх ёстой вэ?
- ✓ Дотно харилцаатай хүмүүсийн хоорондох харилцаанд хувь хүний эрхийг зөрчиж буй ямар нийтлэг жишээ байдаг вэ? Үүрэг хариуцлагаа ухамсарлахгүй байгааг харуулсан нийтлэг тохиолддог ямар жишээнүүд байдаг вэ?
- ✓ Үерхдэг дотны найзыгаа чамтай хэрхэн харилцвал өөрийн чинь эрхийг үл хүндэтгэн, хүсэлт хэрэгцээг чинь харгалзахгүй байна гэж үзэх вэ?
- ✓ Дотны хүнтэйгээ харилцахад хувь хүний орон зай, хил хязгаарыг харгалзах ёстой юу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад?

**Багшийн анхаарах зүйл:** Үнэлгээний даалгаврыг өгөхдөө эсээ бичих чиглэл буюу асуултыг зөвхөн хэлээд өнгөрч болохгүй. Эсээ бичих удирдамж, үнэлгээний рубрикийг танилцуулж, шаардлагатай бол эдгээрийг харах боломжтой байдлаар цахим орчинд байрлуулах эсвэл хэвлэмэл хувилбарыг тарааж өгнө.

Эсээг үнэлэхдээ үнэлгээний зорилгоо санаж байх нь чухал. Бид тус даалгаврын гүйцэтгэлээр дараах зүйлсийг мэдэх боломжтой. Үүнд:

- ✓ Дотно харилцаан дахь эрх, үүргийн талаар мэддэг болсон эсэх
- ✓ Дотны хүнтэйгээ болон бусадтай харилцахдаа өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг хүндэтгэх нь чухал болохыг хүлээн зөвшөөрөх хандлага бий болсон эсэх

Үүнийг үнэлэхдээ дараах рубрикийг ашиглаж болно. Рубрикийн шалгуурын эхний 2 нь дээр өгүүлсэн мэдлэг, хандлагыг үнэлэхэд чиглэгдэнэ. Харин бусад шалгуур сурах арга барил талаас нь даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхэд чиглэгдсэн болно.

## Эсээг үнэлэх рубрик

Шалгуур	Гүйцэтгэлийн түвшин	
Мэдлэг	4	Дотно харилцаан дахь үндсэн 5 эрх, 3 үүрэг хариуцлагыг бүгдийг нэрлэж, тэдгээр тус бүрт 3-аас дээш жишээ гарган тайлбарласан
	3	Дотно харилцаан дахь үндсэн 4-5 эрх, 3 үүрэг хариуцлагыг нэрлэж тэдгээр тус бүрт 3-аас доошгүй жишээ гарган тайлбарласан
	2	Дотно харилцаан дахь үндсэн эрхээс 2-3-ыг, үүрэг хариуцлага 1-2-ыг нэрлэж, тэдгээр тус бүрт 1-2 жишээ гарган тайлбарласан
	1	Дотно харилцаан дахь үндсэн эрх, үүрэг хариуцлагаас ганц нэгийг бичсэн боловч жишээ гаргаагүй
Хандлага	4	Үерхдэг дотны найз байсан ч түүний эд зүйлд дураараа хүрч, өмнөөс нь шийдвэр гаргах ёсгүй, тухайн хүний хүсэл хэрэгцээг хүндэтгэх ёстой гэсэн үзэл санааг илэрхийлсэн
	3	Үерхдэг дотны найз байсан ч түүний хүсэл хэрэгцээ, хувийн орон зайг хүндэтгэн харилцах ёстой гэсэн санааг илэрхийлсэн
	2	Хувь хүний орон зай, хил хязгаар гэж байдаг ч үерхдэг дотны найзууд учраас өмнөөс нь зарим тохиолдолд шийдвэр гаргаж болно гэсэн санааг илэрхийлсэн
	1	Хувь хүний хил хязгаарыг зөрчиж, хүсэл хэрэгцээг үл ойшоохыг хүлээн зөвшөөрөх санаа бодол, итгэл үнэмшлийг илэрхийлсэн
Үндсэн санааг бичсэн байдал	5	Үндсэн санааг маш сайн илэрхийлж, тусгасан
	4	Үндсэн санааг ерөнхийдөө сайн тусгасан
	3	Үндсэн санааг тусгасан боловч төдийлөн оновчтой үг, өгүүлбэрээр илэрхийлээгүй
	2	Үндсэн санаа нь сэдэвтэй төдийлөн уялдаагүй, оновчтой үг, өгүүлбэрээр илэрхийлээгүй
	1	Үндсэн санаа маш хангалтгүй
Эсээний бүтэц, зохион байгуулалт	5	Бүтцийн хувьд логик дараалал, уялдаа холбоо маш сайн
	4	Бүтцийн хувьд логик дараалал, уялдаа холбоо ерөнхийдөө сайн
	3	Зарим нэг хэсэг бусад хэсэгтэй уялдаа холбоо сул
	2	2 ба түүнээс дээш хэсэг уялдаа холбоогүй
	1	Бүтцийн хувьд эмх замбараагүй
Агуулга	5	Сонгосон сэдэвтэй маш сайн уялдсан, үндсэн ойлголт, жишээ, тоо баримт, мэдээлэл, дүгнэлтийг зөв оновчтой, маш сайн бичсэн
	4	Агуулга нь сэдэвтэйгээ уялдаатай, үндсэн санаатай нийцсэн
	3	Агуулга нь сэдэвтэйгээ ерөнхийдөө уялдаатай боловч хэт өргөн хүрээтэй эсвэл хэт явцуу
	2	Үндсэн санаатай бага зэрэг холбоотой ч агуулга нь төдийлөн тодорхой бус
	1	Үндсэн санаатайгаа огт холбоо хамааралгүй, логикгүй
Утга найруулга	5	Утга найруулгын хувьд маш сайн, үг үсгийн нэг ч алдаагүй
	4	Утга найруулгын хувьд ерөнхийдөө сайн, үг үсгийн алдаагүй
	3	Зарим хэсэг нь найруулгын хувьд алдаатай, үг үсгийн алдаатай
	2	Ихэнх хэсэг нь утга найруулгын хувьд алдаатай, үг үсгийн алдаатай
	1	Бүхэлдээ утга найруулга маш муу, үг үсгийн маш их алдаатай

Эсээний нийт авах оноо 7-28 юм. Үүнийг дараах байдлаар түвшинчилж болно.

- 7-12 хангалтгүй
- 13-18 дунд зэрэг
- 19-24 хангалттай
- 25-28 хангалттай сайн

**Багшийн анхаарах зүйл:** Сурагчийн бичсэн эсээнээс өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг хүндэтгэн хэрхэн харилцах чадвар эзэмшсэн эсэхийг үнэлэх боломжгүй. Тиймээс тус чадварыг үнэлэхэд чиглэсэн үнэлгээний тусдаа даалгавар боловсруулж ашиглах шаардлагатай.

## Үнэлгээний даалгавар 2. Асуулт хариулт / Ярилцлага

Үнэлгээний даалгаврын зорилго:	Харилцааны эрх, үүргийг харгалзан харилцан зөвшилцөх замаар үр дүнтэй харилцах чадварыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Сурагчийн бөглөсөн асуулт хариултын хуудас, түүнд үнэлгээ өгсөн багшийн бүртгэл
Гүйцэтгэх хугацаа:	15-20 минут

Дараах асуулт хариултын хуудсыг сурагчдад тараан өгч ажиллуулна. Эсвэл тус асуулт хариултын хуудсан дахь асуултын дагуу багш сурагчтай ярилцлага хийж болно.

### Асуулт хариултын хуудас

Хамрах сэдэв: \_\_\_\_\_

Сурагчийн нэр: \_\_\_\_\_ Он сар өдөр: \_\_\_\_\_

**Заавар:** Нөхцөлийг анхааралтай уншаад, асуултад хариулна уу.

**Нөхцөл 1:** Дотны найз охин/хөвгүүн чинь хичээлийн дараа үргэлж хамт байхыг хүсэж, ямар нэг зүйл хийхээр шийдчихсэн байдаг. Чи заримдаа гэртээ эсвэл бусад найзуудтайгаа өөр ажилтай учраас түүнтэй хамт байх боломжгүй. Чи тайлбарлахыг хичээдэг боловч чиний үгийг шууд тасалж, хамтдаа байхыг хүсэхгүй байгаа юм уу гэж уурлана.

**Асуулт:** Энэ тохиолдолд чи яах вэ?

**Хариулт:**

1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_
4. \_\_\_\_\_
5. \_\_\_\_\_

**Нөхцөл 2:** Найз чинь өмссөн хувцас, идэж ууж байгаа зүйл, хүмүүстэй юу ярих, хэнтэй харилцах гээд бүхий л зүйлийг чинь хянаж, шүүмжилнэ. Тэр ингэж байгаагаа чиний сайн сайхны төлөө л хийж байгаа юм гэж тайлбарлана.

**Асуулт:** Энэ тохиолдолд чи яах вэ?

**Хариулт:**

1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_
4. \_\_\_\_\_
5. \_\_\_\_\_

**Нөхцөл 3:** Нэгэн хөвгүүн гитар хөгжмөөр тоглож сурахыг ихэд хүсдэг бөгөөд хааяа найзындаа очиж гитар хөгжмөөр нь тоглоно. Гэвч найз охин нь “хэзээ ч бүтэхгүй зүйл, наадахаараа хоолоо олж иднэ гэж байхгүй, хамаг цагаа дэмий зүйлд зарцуулна гэсэн үг” гэж үргэлж хэлнэ. Мөн түүний утас, түрийвч зэргийг дураараа авч үзнэ. Мөнгөтэй явж байвал “зээлчих” гэж хэлээд дураараа авчихна.

**Асуулт:** Хэрвээ чи тэр хөвгүүний оронд байсан бол яах вэ?

**Хариулт:**

1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_
4. \_\_\_\_\_
5. \_\_\_\_\_

**Гүйцэтгэлийг үнэлж, оноожуулах аргачлал:**

Нөхцөл 1-ийн хүрээнд дараах хариултыг бичсэн эсэхийг анхаарна.

- “Би өөртөө цаг гаргах хэрэгтэй байна” гэдгийг хэлэх
- Найз нөхөдтэйгөө эсвэл гэртээ ажилтай учраас амжихгүй гэдгээ хэлж, дотно харилцаатай ч гэсэн заримдаа тусдаа өнгөрүүлэх цаг хэн хэнд маань байх ёстой гэдгийг тайлбарлах
- Уулзмааргүй байгаа үедээ уулзахаас татгалзах
- Яриаг минь таслалгүйгээр анхааралтай сонсохыг хүсэх
- Хийхийг хүсэхгүй байгаа зүйл гарвал татгалзаж байгаагаа хэлэх

Нөхцөл 2-ын хүрээнд дараах хариултыг бичсэн эсэхийг анхаарна.

- Өөрийн хүсэж буй хувцасаа өмсөх нь хувь хүний эрх гэдгийг ойлгуулахыг хичээх
- Өөрийн хүсэж буй зүйлээ идэх нь хувь хүний эрх гэдгийг ойлгуулахыг хичээх
- Өөрийн гэсэн байр суурьтай байж, өөрийн бодож байгаагаа илэрхийлэх нь хувь хүний эрх гэдгийг ойлгуулахыг хичээх
- Өөрийн сэтгэгдлээ илэрхийлэх нь хувь хүний эрх гэдгийг ойлгуулахыг хичээх
- Миний хэрэгцээг өөрийнхтэйгөө нэгэн адил хүндэтгэн үздэг байхыг хүсэх

Нөхцөл 3-ын хүрээнд дараах хариултыг бичсэн эсэхийг үнэлнэ.

- Өөрийн хувийн орон зай, хил хязгаар гэж юу болохыг хэлэх (миний хүсэж байгаа эсвэл хийхийг хүсээгүй зүйл)
- Өөрийнх нь эд зүйлд дураараа хүрэхгүй байхыг хүсэх
- Мөнгө зээлдүүлмээргүй бол түүнийгээ илэрхийлэх
- Намайг үнэлдэг, дэмждэг, миний сайн сайханд итгэдэг байх
- Надад нөлөөлөх шийдвэр гаргахад чин сэтгэлээсээ хандаж, оролцдог байх

Нөхцөл тус бүрийн хүрээнд сурагчийн хариултыг дараах байдлаар оноожуулж, бүртгэх боломжтой.

**Үнэлгээний хуудас:**

Оноо	Шалгуур	Сурагчийн оноо		
		Нөхцөл 1	Нөхцөл 2	Нөхцөл 3
4 оноо	Хариултад тусгагдвал зохих бүхий л санаа бүрэн гарсан			
3 оноо	Хариултад тусгагдвал зохих ихэнх санаа гарсан			
2 оноо	Хариултад тусгагдвал зохих зарим санаа гарсан			
1 оноо	Хариултад тусгагдвал зохих санаа бараг гараагүй			
<b>Нийлбэр оноо</b>				

**Үнэлгээний даалгавар 3. Дүрийн тоглолт ба үе тэнгийнхний үнэлгээ**

Үнэлгээний даалгаврын зорилго:	Өөрийн болон бусдын хүсэлт хэрэгцээ, хил хязгаарыг харгалзан харилцан зөвшилцөх замаар үр дүнтэй харилцах чадварыг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Сурагчийн бөглөсөн асуулт хариултын хуудас, түүнд үнэлгээ өгсөн багшийн бүртгэл
Гүйцэтгэх хугацаа:	20-30 минут

Тус дүрийн тоглолтод өмнө үнэлгээний даалгаварт хэрэглэсэн нөхцөлийг ашигласан болно. Багш хүсвэл өөр нөхцөл боловсруулан ашиглах боломжтой.

Сурагчдыг гурав, гурваар нь бүлэг болгож, сурагч тус бүрт доорх нөхцөлөөс нэг нэгийг, үнэлгээний хуудсын хамт өгнө. 3 сурагч харилцан бие биедээ өөрт оногдсон нөхцөлийг товч танилцуулаад, тухайн нөхцөлд хэрхэн харилцах дүрийн тоглолтыг үзүүлнэ.

**Заавар:** Сурагчид дүрийн тоглолтыг ээлжлэн үзүүлнэ. Өөрт оногдсон нөхцөлд хэрхэн харилцахыг харуулж буй сурагч дүрийн гол тоглогч байх бөгөөд багийн нэг сурагч найзынх нь дүрд тоглон тусална. Харин гурав дахь сурагч үнэлгээний хуудсын дагуу гол тоглогчийн харилцааны чадварыг үнэлж, оноо өгнө.

**Нөхцөл 1:**

Дотны найз охин/хөвгүүн чинь хичээлийн дараа үргэлж хамт байхыг хүсэж, ямар нэг зүйл хийхээр шийдчихсэн байдаг. Чи заримдаа гэртээ эсвэл бусад найзуудтайгаа өөр ажилтай учраас түүнтэй хамт байх боломжгүй. Чи тайлбарлахыг хичээдэг боловч чиний үгийг шууд тасалж, хамтдаа байхыг хүсэхгүй байгаа юм уу гэж уурлана.

Энэ тохиолдолд чи түүнтэй хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

**Нөхцөл 2:**

Найз чинь өмссөн хувцас, идэж ууж байгаа зүйл, хүмүүстэй юу ярих, хэнтэй харилцах гээд бүхий л зүйлийг чинь хянаж, шүүмжилнэ. Тэр ингэж байгаагаа чиний сайн сайхны төлөө л хийж байгаа юм гэж тайлбарлана.

Энэ тохиолдолд чи түүнтэй хэрхэн харилцах вэ? Дүрд тоглож харуулна уу.

**Нөхцөл 3:**

Нэгэн хөвгүүн гитар хөгжмөөр тоглож сурахыг ихэд хүсдэг бөгөөд хааяа найзындаа очиж гитар хөгжмөөр нь тоглоно. Гэвч найз охин нь “хэзээ ч бүтэхгүй зүйл, наадахаараа хоолоо олж иднэ гэж

байхгүй, хамаг цагаа дэмий зүйлд зарцуулна гэсэн үг” гэж үргэлж хэлнэ. Мөн түүний утас, түрийвч зэргийг дураараа авч үзнэ. Мөнгөтэй явж байвал “зээлчих” гэж хэлээд дураараа авчихна.

Хэрвээ чи тэр хөвгүүний оронд байсан бол найз охинтойгоо хэрхэн харилцах вэ?

Дүрд тоглож харуулна уу.

**Дүрийн тоглолтыг үнэлэх үнэлгээний хуудас**

Сурагчийн нэр: \_\_\_\_\_ Он сар өдөр: \_\_\_\_\_

Анги: \_\_\_\_\_ Үнэлгээ өгсөн сурагчийн нэр: \_\_\_\_\_

Чадвар	Маш сайн (3)	Сайн (2)	Сайжруулах шаардлагатай (1)
“Үгүй” гэж хэлэх  Оноо _____	<input type="checkbox"/> Хариулахдаа “Үгүй” гэсэн үгийг хэрэглэдэг. <input type="checkbox"/> Өөрийн байр суурийг маш тодорхой илэрхийлдэг. <input type="checkbox"/> Үндэслэлээ тодорхой илэрхийлдэг.	<input type="checkbox"/> Хариулахдаа “Үгүй” гэсэн үгийг хэрэглэдэг. <input type="checkbox"/> Өөрийн байр суурийг илэрхийлэхдээ санаа зовж, тээнэгэлздэг. <input type="checkbox"/> Үндэслэл хэлдэггүй.	<input type="checkbox"/> “Үгүй” гэсэн үгийг хэрэглэдэггүй. <input type="checkbox"/> Үндэслэл хэлж чаддаггүй.
Биеийн хэлэмж  Оноо _____	<input type="checkbox"/> Ярилцаж буй хүнийхээ нүд рүү эгцлэн хардаг. <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь өөрийн байр суурьт баттайг илэрхийлдэг. <input type="checkbox"/> Инээхгүй, өөр тийшээ харахгүйгээр нухацтай ханддаг. <input type="checkbox"/> Тохиромжтой дохио зангаа хэрэглэдэг. <input type="checkbox"/> Тухайн хүнээс болон газраас зай барин холддог. <input type="checkbox"/> Хэлж байгаа үг ба үйлдэл нь бүрэн нийцтэй.	<input type="checkbox"/> Ярилцаж буй хүнийхээ нүд рүү тохиолдлоор эгцлэн хардаг. <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь өөрийн байр суурьт баттайг тохиолдлоор илэрхийлдэг. <input type="checkbox"/> Нухацтай хандах оролдлого хийдэг. <input type="checkbox"/> Дохио зангаа бага хэрэглэдэг. <input type="checkbox"/> Тухайн нөхцөл байдлаас холдох зарим оролдлого хийдэг. <input type="checkbox"/> Хэлж байгаа үг ба үйлдэл нь ихэнхдээ нийцсэн.	<input type="checkbox"/> Ярилцаж буй хүнийхээ нүд рүү эгцлэн хардаггүй. <input type="checkbox"/> Дуу хоолойны өнгө нь өөртөө итгэлгүй. <input type="checkbox"/> Инээж, өөр тийшээ хардаг. <input type="checkbox"/> Тохиромжтой бус дохио зангаа хэрэглэдэг. <input type="checkbox"/> Тухайн нөхцөл байдлаас холддоггүй. <input type="checkbox"/> Үг ба үйлдэл нь зөрдөг.
Татгалзаж байгаагаа давтан илэрхийлэх  Оноо _____	<input type="checkbox"/> Нөгөө хүн дарамт үзүүлэхээ зогсоох хүртэл анх хэлсэн “үгүй” гэдэг үгээ давтан хэлдэг. <input type="checkbox"/> “Үгүй” гэж өмнөхөөсөө хүчтэй хэлдэг. <input type="checkbox"/> Өөрт нь ямар санагдаж байгааг хэлдэг. <input type="checkbox"/> Тус үйлдлээс гарч болох нэлээд хэдэн үр дагаврыг хэлдэг.	<input type="checkbox"/> “Үгүй” гэж давтан хэлэх боловч эцэст нь бууж өгдөг. <input type="checkbox"/> “Үгүй” гэж өмнөхөөсөө хүчтэй хэлэх оролдлого хийдэг. <input type="checkbox"/> Өөрт нь ямар санагдаж байгааг хэлэхийг оролддог. <input type="checkbox"/> Тус үйлдлээс гарч болох 1, 2 үр дагаврыг хэлдэг.	<input type="checkbox"/> “үгүй” гэж давтан хэлдэггүй. <input type="checkbox"/> Байгаа байдал, дуу хоолойны өнгөө өөрчилж чангаруулдаггүй. <input type="checkbox"/> Өөрт нь ямар санагдаж байгааг хэлдэггүй. <input type="checkbox"/> Тус үйлдлээс гарч нэг ч үр дагавар хэлдэггүй.

Өөр хувилбар санал болгох  Оноо _____	<input type="checkbox"/> Хүнд хүрэхээр, бодитой хэд хэдэн хувилбар санал болгодог. <input type="checkbox"/> Тухайн нөхцөл байдлаас гарах өөр үйлдэл санал болгодог. <input type="checkbox"/> Тус санал болгосон өөр хувилбар руу чиглэсэн үйлдэл хийдэг.	<input type="checkbox"/> Нэг хувилбар санал болгодог. <input type="checkbox"/> Тус санал болгосон хувилбар руу чиглэсэн үйлдэл хийхийг оролддог.	<input type="checkbox"/> Ямар ч хувилбар санал болгодоггүй.
Харилцаа холбоогоо хадгалах  Оноо _____	<input type="checkbox"/> Бат бөх, шударгаар тууштай харилцдаг <input type="checkbox"/> “Би” өгүүлэмжийг хэрэглэдэг. <input type="checkbox"/> Бусад хүмүүсийн хүсэлт, хэрэгцээг хүлээн авснаа болон талархаж байгаагаа илэрхийлдэг.	<input type="checkbox"/> Бат бөх, шударга, тууштай харилцах оролдлого хийдэг. <input type="checkbox"/> “Би” өгүүлэмжийг тохиолдлоор хэрэглэдэг. <input type="checkbox"/> Бусад хүний хүсэлт, хэрэгцээг хүлээн авч байгаагаа илэрхийлэх оролдлого хийдэг.	<input type="checkbox"/> Худлаа хэлдэг <input type="checkbox"/> Тухайн нөхцөл байдлыг наргиа болгодог. <input type="checkbox"/> Бусдын хүсэлт, хэрэгцээг доог тохуу болгодог.
Нийлбэр оноо: _____			

Жич: Дээрх 5 шалгуур тус бүрээр 1-3-ын хооронд оноо өгөх ба нийт авах ёстой оноо 5-15 байна. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн үнэлнэ.

- 5-8 хангалтгүй
- 9-12 дунд зэрэг
- 13-15 хангалттай

**Багшийн анхаарах зүйл:** Дүрийн тоглолтоо үзүүлэхдээ бодит амьдрал дээр тус нөхцөлд хэрхэн хандахыг чин сэтгэлээсээ илэрхийлэн, тоглоом шоглоом болгохгүйгээр өгөдсөн хугацаанд хийж гүйцэтгэхийг сурагчдад анхааруулна. Үнэлгээ хийхдээ өгсөн шалгуурын дагуу үнэн зөв, бодитой, шударга үнэлэхийг сануулна.

#### Үнэлгээний даалгавар 4. Сурталчилгааны материал боловсруулах

Үнэлгээний даалгаврын зорилго:	Мэдээллийн янз бүрийн эх сурвалжаас бэлгийн амьдралын талаар бодитой, зөв мэдээлэл олж авах чадвар, хандлага эзэмшсэн эсэхийг үнэлэх
Үнэлгээний төрөл:	Явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой
Даалгаврын хэлбэр:	Задгай
Нотлох баримт:	Оновчтой хэлбэрээр боловсруулсан сурталчилгааны материал, багшийн үнэлгээ тавьсан хуудас
Гүйцэтгэх хугацаа:	2 долоо хоног

**Багшийн анхаарах зүйл:** Үнэлгээний даалгаврын дараах удирдамжийг сурагчдад танилцуулна. Хийж гүйцэтгэх хугацаа болон гүйцэтгэлийг хэрхэн үнэлэх талаар тайлбарлах хэрэгтэй.

Бэлгийн амьдралын талаарх мэдээллийн найдвартай эх сурвалжийг тодорхойлж, ашиглах талаар үе тэнгийнхэндээ зориулсан сурталчилгааны материал боловсруулах ажлын удирдамж

Алхам 1. Тус сурталчилгааг хийх нь яагаад чухал болохыг илэрхийлсэн үндэслэл бичих, 2 жишээ гаргасан байх (5 оноо)

Алхам 2. Үе тэнгийнхэндээ зориулан бэлгийн амьдралын талаарх мэдээллийн найдвартай эх сурвалжийг тодорхойлж, зөв баталгаатай мэдээллийг олж хэрэглэдэг болох талаар сурталчилгааны материал боловсруулах

- Хийх гэж буй сурталчилгааны ажлын зорилгыг тодорхойлох. Хүрэхийг хүсэж буй 2 зүйлээ тодорхойлж бичих (2 оноо)
- Сурталчилгааны ажлынхаа хүрээнд бусдад хүргэхийг хүссэн түлхүүр мэдээлэл буюу гол 2 санааг тодорхойлох (2 оноо)
- Дээрх түлхүүр 2 мэдээллийг бусдад хүргэхийн тулд ашиглах 2 арга замыг боловсруулах. Тус арга зам нь тухайн сонгон авсан насныханд тохиромжтой, хүртээмжтэй байна. (тус бүр 2, нийт 4 оноо) Дараах арга замаас сонгон авч болох ба зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй.
  - Үзүүлэн
  - Инфографик мэдээлэл
  - Тараах материал
  - Видео бичлэг
  - Слайд танилцуулга
  - Аудио мэдээлэл
  - Ханын самбар
- Сонгосон арга нь холбогдох тоо баримт, мэдээллийг агуулсан (тус бүр 3, нийт 6 оноо)
- Сурагчдад өгөх 3 зөвлөмжийг багтаасан байх (тус бүр 2, нийт 6 оноо)

Алхам 3. Эргэцүүлэл хийх (8 оноо)

- Тус сурталчилгаа нь тавьсан зорилтдоо хүрэх буюу амжилттай болох эсэх талаар ямар бодолтой байгаа, яагаад ийнхүү бодож байгаагаа бичих
- Бэлгийн амьдралтай холбоотой мэдээллийн найдвартай эх сурвалжийг ялган тодорхойлж, түүнийг ашигладаг болох дадал хэвшил сурагчдад бий болгоход саад болох 3 зүйлийг тодорхойлох
- Бэлгийн амьдралтай холбоотой мэдээллийн найдвартай эх сурвалжийг ялган тодорхойлж, түүнийг ашигладаг болох дадал хэвшил сурагчдад бий болгоход туслах өөр 2 арга замыг тодорхойлох

**Оноожуулах аргачлал:**

Үнэлэх зүйл	Оноо
<b>Алхам 1. Үндэслэл гаргах</b>	
Үндэслэл нь холбогдох бүх мэдээллийг багтаасан цогц байвал	3 оноо
Үндэслэл нь холбогдох мэдээллийг багтаасан ба тодорхой байвал	2 оноо
Үндэслэл нь маш бага мэдээлэл, тайлбар оруулсан товч байвал	1 оноо
2 жишээ гаргах ба гаргасан жишээ тус бүрт 1 оноо	2 оноо
<b>Нийт</b>	<b>5 оноо</b>
<b>Алхам 2. Сурталчилгааны материалыг боловсруулах</b>	
Сурталчилгааны зорилго – тухайн насныханд хамааралтай, тодорхой, хүрч болохуйц 2 зүйлийг багтаасан	1-2 оноо
Түлхүүр мэдээлэл нь зорилтот бүлэгт хамааралтай, ойлгомжтой, зөв байх	1-2 оноо
Сурталчилгааны арга зам:	
Сурталчилгааны арга зам тус бүрээр түлхүүр мэдээллийг ойлгомжтой хүргэх	1-4 оноо
Холбогдох тоо баримт, мэдээллийг багтаасан	1-6 оноо
Тухайн насныханд тохирсон үнэн зөв, холбоо хамаарал бүхий 3 зөвлөмжийг багтаасан	1-6 оноо
<b>Нийт</b>	<b>20 оноо</b>



<b>Алхам 3. Эргэцүүлэл хийх</b>		
Урьдчилан таамаглаж буй амжилтыг тодорхойлсон байдал (3 оноо)		1-8 оноо
Дадал хэвшил бий болгоход саад болох 3 зүйл (3 оноо)		
Дадал хэвшил бий болгоход туслах нэмэлт 2 арга зам (2 оноо)		
	Нийт	8 оноо
<b>БҮГД</b>		<b>33</b>

Сурталчилгааны материал боловсруулах үнэлгээний даалгаврыг гүйцэтгэснээр 7-33 оноо авах боломжтой. Тус оноог дараах байдлаар түвшинчлэн сурагчийг үнэлнэ.

- 7- 13 хангалтгүй
- 14-20 дунд зэрэг
- 21-27 хангалттай
- 28-33 хангалттай сайн

## Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Тус нэгжийн хүрээнд бид сонгох даалгаврын нийт 24 асуулт бүхий 2 хувилбар, 4 төрлийн задгай даалгаврыг боловсруулсан. Эдгээрийг хэрхэн ашиглаж, дүн шинжилгээ хийх талаар авч үзье.

Сонгох даалгаврын эхний хувилбар нь зөвхөн “Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэл” сэдвийн хүрээг хамарсан бөгөөд мэдлэг, хандлагыг үнэлэхэд чиглэгдсэн. Үүнийг явцын үнэлгээнд ашиглахад маш тохиромжтой. Гарааны болон үр дүнгийн үнэлгээний даалгаврын нэг бүрэлдэхүүн хэсэг болгон ашиглах боломжтой.

Сонгох даалгаврын 2 дахь хувилбар нь “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” нэгжийг бүхэлд нь хамарсан боловч сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг өөрийн үнэлгээнд тулгуурлан үнэлэхэд түлхүү анхаарсан. Хандлагын төлөвшлийг харах боломжгүй. Тус үнэлгээг гарааны, явцын, үр дүнгийн үнэлгээнд ашиглах боломжтой. Гэхдээ дараах байдлаар хэрэглэвэл тохиромжтой. Тухайлбал, гарааны үнэлгээ болон үр дүнгийн үнэлгээнд зэрэг ашиглах, эсвэл явцын болон үр дүнгийн үнэлгээнд ашиглах гэсэн хувилбар байж болно. Харин гараа, явц, үр дүнгийн үнэлгээнд дараалуулан ашиглавал сурагчид залхах магадлалтай.

Хэрвээ гарааны үнэлгээнд ашигласан бол тус бүлэг сэдвийг судалсны дараа сурагч түүнийг дахин ашиглан, өөртөө дүн шинжилгээ хийх боломжтой. Эсвэл гарааны үнэлгээнд ашиглалгүй явцын үнэлгээнд ашиглаж, мөн дээрхийн адил жилийн эцэст үр дүнгийн үнэлгээ болгон ашиглах боломжтой. Өөрийн үнэлгээг дангаар нь дүн тавих үнэлгээ болгон ашиглах боломжгүй тул бусад үнэлгээтэй хамт хэрэглэж, дүн шинжилгээ хийх нь тохиромжтой. Сурагчийн өөрийн үнэлгээ бусад үнэлгээтэй хэр зэрэг нийцэж буйг багш харьцуулан дүн шинжилгээ хийх хэрэгтэй (Доор өгсөн хүснэгтээс харна уу).

Тус нэгжийн үнэлгээнд ашигласан үнэлгээний даалгаврын төрөл тус бүрээр авсан оноог ижил хэмжээст шилжүүлэн, дараах байдлаар нэгтгэн, сурагч тус бүрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж болно.

Үнэлгээний даалгаврын төрөл	Гүйцэтгэлийн шалгуур 1	Гүйцэтгэлийн шалгуур 2	Гүйцэтгэлийн шалгуур 3
Өөрийн үнэлгээ	( )	( )	( )
Сорил		( )	
Эсээ			( )
Асуулт хариулт	( )		
Дүрийн тоглолт	( )		
Сурталчилгааны материал			( )
Нийт оноо	( )	( )	( )
Дундаж оноо	( )		

Багш хичээлийн үр дүнг сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг танин мэдэхүйн эсвэл гүйцэтгэлийн түвшнээр нь харьцуулан задлан шинжлэх боломжтой.

Үнэлгээний даалгаврын төрөл	Гүйцэтгэлийн түвшин 1	Гүйцэтгэлийн түвшин 2	Гүйцэтгэлийн түвшин 3	Гүйцэтгэлийн түвшин 4
Өөрийн үнэлгээ				
Сорил				
Эсээ				
Асуулт хариулт				
Дүрийн тоглолт				
Сурталчилгааны материал				
Нийт оноо				
Дундаж оноо				

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Антони Ж.Нитко., Сюзан М.Брүүкхарт, 2011. Суралцагчдын эзэмшсэн боловсролыг үнэлэх арга зүй. 6 дахь хэвлэл.
2. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Мөнгөнтулга.Э., ба бусад. 2018. Эрүүл мэнд. Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж. Улаанбаатар.
3. Алтанцэцэг,Д., Байгалмаа,Ч., Жаргал.Б., ба бусад. 2020. Суурь, бүрэн дунд боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж. Эрүүл мэндийн багшид зориулсан гарын авлага. VI-XII анги. Улаанбаатар.
4. Мөнгөнтулга.Э., Дарамбазар., Лхамсүрэн.В. 2019. Эрүүл мэнд Х. Ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн сурах бичиг. Улаанбаатар.



**ЕБС-ийн Эрүүл мэнд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

Ч.Байгалмаа

МУБИС-ийн БСС-ийн багш

Ц.Дийдэрмаа

Нийслэлийн ЕБ-ын 47 дугаар сургуулийн багш

**Хөндлөнгийн шинжээч:**

Э.Мөнгөтулга

МУБИС-ийн МБУС-ийн багш

**Техникийн редактор:**

Д.Энхжаргал

Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр

Ш.Сувдмаа

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

С.Мөнхмаа

Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

**Цаасны хэмжээ:**

A4

**Хэвлэлийн хуудас:**

3.5 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-мэйл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)